МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.10.08 № ХЗГ/3414

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН БАТБАЯРЫН ЖАРГАЛАН
ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Танаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан 2026 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 51 дугаартай албан бичгээр "Туулын хурдны замын талаар" тавьсан асуулгын 1-6 дугаар асуултын хариуг Нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн тайлбар, мэдээллийн хамт хүргүүлж байна.

Асуулгын 7 дугаар асуултын хувьд “Туулын хурдны зам” төслийн хэрэгжилттэй холбоотой асуудлыг нягтлан шалгах хүрээнд төслийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх, гэрээлэгч талтай шаардлагатай хэлэлцээ хийх, төслийг цаашид хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн болон нийтийн эрх ашигт үзүүлэх нөлөөлөл, төсөв, санхүүгийн үр дагавар болон болзошгүй эрсдэлийг бүх талаар тооцон үзэх, улмаар гэрээг үргэлжлүүлэх эсэх асуудлыг хууль тогтоомж болон гэрээнд заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх үүрэг, чиглэлийг Засгийн газраас холбогдох албан тушаалтнуудад өгсөн болно.

Хавсралт 05 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХБАЯР

000265009193

МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 39 77, 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2026.09.28 № 01/6169

танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан 2026 оны 51 дүгээр албан бичгээр ирүүлсэн "Туулын хурдны зам" төслийн талаарх асуулгатай холбоотой тайлбар, мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 4. хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Б.ПҮРЭВДАГВА

C:\Users\DELL\2026 он\Засаг дарга\ЗД-А5.docx

1726140550

Нийслэлийн Засаг даргын 2026 оны
09 дугаар сарын 28 өдрийн
01/6169 албан бичгийн
хавсралт

Улсын Их Хурлын гишүүний асуулгатай холбоотой *"Туулын хурдны зам" төслийн талаарх тайлбар, мэдээлэл*

1."Туулын хурдны зам" төсөлд 2025 онд 401.0 тэрбум, 2026 онд 99.0 тэрбум төгрөг буюу нийт 500.0 тэрбум төгрөгийн урьдчилгаа олгож, Туул голын сав газар дахь мод, бут, сөөгийг огтолж, байгаль орчинд хохирол учруулсан шийдвэрийн хариуцлагыг хэн хүлээх вэ? Энэхүү 500.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт бүрэн буцаан төвлөрүүлж, төсөв болон байгаль орчинд учирсан хохирлыг нөхөн төлүүлэн, улсыг хохиролгүй болгох талаар Монгол Улсын Засгийн газар ямар арга хэмжээ авч, хэзээ хэрэгжүүлэх вэ?

Хариулт: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Хятадын Хаоюань групп" ХХК болон "Тяньжин өүбайвэй" ХХК-ийн түншлэлтэй 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдөр НХААГ/20250101139 дугаартай гэрээг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 78 дугаар тогтоолын дагуу Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо /Фидик/-ны гэрээний жишиг нөхцөлийг хэрэглэн байгуулсан.

Дээрх гэрээний хавсралт болох 2/А/ Гэрээний мэдээлэл хэсгийн 14.2-т гэрээний үнийн дүнгийн 21.32 хувь буюу 500.0 тэрбум төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгохоор тусгасан бөгөөд Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо /Фидик/-ны гэрээний Мөнгөн номны жишиг нөхцөлийн 14.2.1-т "Гүйцэтгэгч нь урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцэх мөнгөн дүнгээр болон валютаар Урьдчилгаа төлбөрийн баталгааг (өөрийн зардлаар) гаргуулах бөгөөд эх хувийг Захиалагчид, хуулбарыг нь Инженерт тус тус хүргүүлэх үүргийг хүлээнэ. Энэхүү баталгааг тухайн улс орны (эсхүл өөр улсын) Захиалагчийн зөвшөөрсөн хуулийн этгээдээр гаргуулах бөгөөд тендерийн баримт бичгээр өгөгдсөн маягт эсхүл Захиалагчийн зөвшөөрсөн маягтыг ашиглана." гэж заасны дагуу гүйцэтгэгчийн гаргасан төлбөрийн баталгааг үндэслэн урьдчилгаа төлбөрийг төлсөн.

2.Дээрх урьдчилгааг нарийвчилсан ажлын төлөвлөгөө, тоо хэмжээ, гүйцэтгэлийн хуваарьгүйгээр олгосон төдийгүй гүйцэтгэгчийн тайлагнасан 350.9 тэрбум төгрөгийн зарцуулалт нь дансны үлдэгдэлтэй зөрсөн, анхан шатны баримт ирүүлээгүйгээс Үндэсний аудитын байгууллага зарцуулалтыг баталгаажуулж чадаагүй байна. Иймд урьдчилгааны зарцуулалт, өнөөгийн үлдэгдэл, бодит гүйцэтгэл, тайлангийн зөрүүг шалгаж тулгасан тоо, баримтыг ирүүлнэ үү. Баталгаажаагүй зарцуулалт болон учирсан хохирлыг хэнээр нөхөн төлүүлэх, шийдвэр гаргасан болон хэрэгжүүлсэн албан тушаалтан, гүйцэтгэгчид ямар хариуцлага хэзээ тооцох вэ?

Хариулт: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-т "Тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу баталгаа гаргасан бол ажлын бэтгэл ажлыг хангахад зориулан урьдчилгаа төлбөр төлнө.", Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.12-т "Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно:" Үүнд: "тухайн төсөл, арга хэмжээнд урьдчилгаа олгох талаар худалдан авах ажиллагааны баримт бичиг болон гэрээнд тусгасан байх;", мөн "урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулсан байх (Сангийн сайдын тушаалаар баталсан "Урьдчилгаа төлбөрийн баталгаа болон даатгалын маягт"-ын дагуу гаргана) гэсэн нөхцөл, шаардлагыг хангасны дагуу гүйцэтгэгчээс ирүүлсэн даатгалын урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн ажлын бэлтгэл хангахад зориулан урьдчилгаа төлбөрийг олгосон байна.

3. 2025 оны 08 дугаар сарын 05-нд "Хятадын ХаоЮань групп" болон "Тяньжин Өүбайвэй"- тэй байгуулсан НХААГ/20250101139 дугаартай, 2.345 их наяд төгрөгийн гэрээг төсөл эхлүүлэх эрх, бүрэн зураг төсөл, магадлалын дүгнэлтгүй үед байгуулсан, тендерийн хугацаа, үнийн нөхцөл болон FIDIC-ийн нөхцөл зөрүүтэй, гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэлтэй гэсэн аудитын дүгнэлтэд Засгийн газар ямар хариулт өгөх вэ? Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Б.Пүрэвдагва 2026 оны 08 дугаар сарын 21-ний өдөр UNCCD COP17-ын хүрээнд зохион байгуулсан "Хотын дарга нарын чуулга уулзалт"-ын үеэр "Туулын хурдны зам гэсэн ойлголт байхгүй болсон. Хуучин трассаар энэ зам хийгдэхгүй. ... Өөр зам хийхээр хэлэлцэж, төлөвлөж байна." гэж мэдэгдсэн. Ийм ноцтой зөрчилтэй гэрээг цуцалж, хуулийн дагуу дахин сонгон шалгаруулалт явуулахын оронд дээрх компаниудтай өөр трассаар, өөр төсөл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь хууль зүйн болон эдийн засгийн хувьд үндэслэлтэй гэж үзэж байгаа эсэх, хэрэв үргэлжлүүлэх бол ямар эрх зүйн акт, судалгаа, тооцоо, дүгнэлтэд үндэслэж байгааг тодорхой тайлбарлана уу.

Хариулт: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Хятадын Хаоюань групп" ХХК болон "Тяньжин Өүбайвэй" ХХК-ийн түншлэлтэй 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдөр НХААГ/20250101139 дугаартай гэрээг байгуулсан бөгөөд тус төсөл нь 2014 оны зургийн шинэчилсэн төсвийн дагуу 4 эгнээ бүхий 32 км авто замыг 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн магадлалын дүгнэлтийн дагуу 916,308.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй байхаар батлагдсан.

Томоохон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн ээлжит хуралдаанаар, Туулын хурдны замыг 6 эгнээ болгох, төвийн бүсийн хэсгээр дайран өнгөрч байгаа хэсгийг гүүрэн байгууламжаар төлөвлөх шийдвэр гарсан. Энэ шийдвэртэй холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Төсөвт өртөгт өөрчлөлт оруулах тухай" 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/02 дугаар тогтоол гарч, тус ажлын төсөвт өртөг 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр гарсан магадлалын дагуу 1,964,788.8 сая төгрөг болж нэмэгдсэн.

Тухайн төслийг нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих авто замын томоохон төсөл, арга хэмжээтэй уялдуулах явцад нэгдүгээр тойрог замтай холбогдох зарим байрлалд гүүрэн байгууламжийн уртыг нэмэгдүүлэх шаардлага үүссэн. Үүний хүрээнд гүүрэн байгууламжийн урт 6771 метр байсныг 9878 урт метр болгон нэмэгдүүлсэн. Түүнчлэн Зам, тээврийн сайдын 2024 оны А/243 дугаар тушаалаар ажилчдын цагийн тарифт цалин болон машин механизмын ашиглалтын нэг машин цагийн үнийн жишиг шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор техник, эдийн засгийн үндэслэл болон урьдчилсан зураг, төсөлд тусгагдсанаар төсвийг шинэчлэн тооцох шаардлага үүссэн болно.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Төсөвт өртөгт өөрчлөлт оруулах тухай" 2025 оны 25/70 дугаар тогтоолоор тус ажлын төсөвт өртөг 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн гарсан магадлалын дагуу 2,384,013.8 сая төгрөг болж нэмэгдсэн.

4."Туулын хурдны зам" төслийг хэрэгжүүлж эхэлснээс хойш ТЭЗҮ, зураг төсөл, БОНҺҮ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, газар чөлөөлөлт, зөвлөх үйлчилгээ болон бусад суурь судалгаа, бэлтгэл ажилд зарцуулсан төсвийн нийт дүнг ажил, гэрээ тус бүрээр нь задалж ирүүлнэ үү. "Туулын хурдны зам" төсөлд зарцуулсан уг хөрөнгийн хэдийг нь төсөвт буцаан төвлөрүүлэх, үр ашиггүй зардал, учирсан хохирлыг хэнээр нөхөн төлүүлж, холбогдох албан тушаалтнуудад ямар хариуцлага тооцох вэ?

Хариулт: "Туулын хурдны зам" төслийн хүрээнд ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1326 дугаар захирамжийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1-д заасны дагуу "Эм Си Пи Си жи ар" ХХК-тай 4,200,000,000 төгрөгийн

үнийн дүнтэй гэрээ байгуулан ажиллаж байсан боловч зөвлөх байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болсон асуудлаас шалтгаалан ажил гүйцэтгэх боломжгүй болсон тул "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-тай тус ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх 100,000,000 төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулан ажилласан болно.

Тус асуулгад дурдсан бусад ажил болох Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон судалгааны ажлыг төслийн үндсэн гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлсэн болно. Эдгээр ажлын зардлын нарийвчилсан мэдээлэл одоогоор гарах боломжгүй бөгөөд төсөл үргэлжлэх эсвэл гэрээ цуцлах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын дагуу зам, барилгын ажлын зардлыг гүйцэтгэлээр нь холбогдох санхүүжилтийн баримт бичгт үндэслэн гаргах боломжтой байна.

5.Шалгалтаар төслийн ажлын зургийг 2026 оны 03 дугаар сарын 13-нд баталж, зам барилгын ажлын зөвшөөрлийг 3 дугаар сарын 15-нд олгосны дараа Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 03 дугаар сарын 19-нд, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 4 дүгээр сарын 17-нд баталсан, мен археологи, палеонтологи, угсаатны зүйн судалгаа болон шаардлагатай зөвшөөрлүүд бүрдээгүй байсан нь тогтоогдсон. ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл, магадлал, ус үер, хөрс ургамал, ойн сан, археологи, палеонтологи, угсаатны зүйн зэрэг суурь судалгаа бүрэн хийгдээгүй байхад зөвшөөрлийн дараалал зөрчиж ажил эхлүүлсэн, шийдвэр гаргасан болон хэрэгжүүлсэн албан тушаалтнуудын нэр, албан тушаал, гаргасан шийдвэрийн огноо, дугаар, эрх зүйн үндэслэл болон тухайн албан тушаалтнуудад ямар хариуцлага тооцсон эсхүл тооцох талаарх мэдээллийг ирүүлнэ үү.

Хариулт: Тус төслийн ажил эхлүүлэх зөвшөөлийг Зам, тээврийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам"-ын 4 дүгээр хавсралтад заасны дагуу холбогдох баримт бичгт үндэслэн олгосон бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар төслийн ажлыг зогсоох шийдвэр гарсантай холбогдуулан тус "Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл"-ийг цуцалсан болно.

6.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Б.Пүрэвдагва 2026 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Туулын хурдны замын бүтээн байгуулалт болон нийслэлийн бусад асуудлаар сэтгүүлчдэд мэдээлэл өгөхдөө "Туулын хурдны замын асуудал Арбитрын шүүхэд шилжиж бид зам ч үгүй, мөнгө ч үгүй болох эрсдэлтэй байсан. Нийслэлээс гүйцэтгэгч компанитай хийсэн хэлэлцээрийн үр дүнд тэр аюул байхгүй болсон. Шүүхийн процесс дуусахыг хүлээж байна..." гэж мэдэгдсэн. Энэхүү мэдэгдлийн хууль зүйн үндэслэл юу вэ? Гэрээний маргаан шийдвэрлэх зохицуулалт, холбогдох хууль, дүрэм, гүйцэтгэгчээс ирүүлсэн мэдэгдэл ба төлбөрийн шаардлага, мөн гэрээ, гүйцэтгэсэн ажлын төлбөр, алдагдсан ашиг, болзошгүй торгууль, нөхөн төлбөрийн тооцооллыг гаргаж, Монгол Улсыг эрсдэлд оруулах гэрээ байгуулсан, уг үйлдэлдээ хариуцлага хүлээвэл зохих албан тушаалтныг нэрлэнэ үү.

Нийслэл Улаанбаатар хотод "Туулын хурдны зам" барих барилгын ажлын зураг төсөл боловсруулах, худалдан авах, барилгын ажил гүйцэтгэх гэрээний ерөнхий нөхцөлийн 8.9, 15.5-д зааснаар Захиалагч нь ажлыг бүхэлд нь болон хэсэгчлэн хэзээ ч түр зогсоох, мөн гэрээг дангаар цуцлах эрхтэй байхаар заасан. Харин гэрээний ерөнхий нөхцөлийн 8.12 болон 16.2.1.g-д гэрээнд заасан түр зогсолт нь 84 хоногоос дээш хугацаагаар үргэлжилсэн бол гүйцэтгэгч ажлаа үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэн мэдэгдэл Захиалагчид гаргах эрхтэй ба тухайн түр зогсолт нь ажилд бүхэлд нь нөлөөлсөн бол Гүйцэтгэгч нь 16.2-т заасны дагуу гэрээг цуцлах мэдэгдэл өгч болно гэж заасан.

Гэрээний талууд гэрээний нөхцөлийг өөрчлөх, түр зогсолтын хугацаа болон нөхөн төлбөрийн нөхцөлийг тодорхойлох асуудлаар хэлэлцээр хийх бөгөөд хэлэлцээр амжилтгүй бол тусгай нөхцөлийн 21.1-т заасны дагуу талуудын хооронд үүссэн маргааныг нөгөө

талдаа бичгээр мэдэгдэл хүргүүлж, харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх ажиллагааг эхлүүлж, 14 хоногт багтаан маргааныг зөвшилцөн шийдвэрлэж чадаагүй бол удирдлагын хороогоор шийдвэрлүүлэх хүсэлтийг гаргана. Удирдлагын хороо маргаантай асуудлаар санал нэгдэж чадвал энэ тухай шийдвэрээ бичгээр гаргаж, хорооны нийт гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

Төслийн гүйцэтгэгч болох Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Хаоюань Женерал Констракшн" ХХК-аас барилга угсралтын ажлын талбайд өнөөдрийн байдлаар гүйцэтгэсэн ажлын хэмжээ болон ажлын зогсолтын хугацаанд гарсан зардлыг нөхөн төлүүлэхээр дараах төлбөрийн нэхэмжлэлүүдийг ирүүлсэн байна. Үүнд:

-2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр ирүүлсэн I үе шатны нэхэмжлэл: 30,864,937,961.09 төгрөг;
-2026 оны 07 дугаар сарын 20-ны өдөр ирүүлсэн II үе шатны нэхэмжлэл: 9,051,800,770.28 төгрөг;
-2026 оны 08 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн III үе шатны нэхэмжлэл: 7,001,186,873.64 төгрөг;
-2026 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр ирүүлсэн IV үе шатны нэхэмжлэл: 31,190,287,383.13 төгрөг.

Ингэснээр 2026 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн байдлаар нийт 78,108,212,988.14 төгрөгийн төлбөрийн нэхэмжлэлийг тус компанийн зүгээс ирүүлээд байна.

Удирдлагын хороо маргааныг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Маргаан шийдвэрлэх зөвлөлийг ажиллуулна. Гэрээнээс үүссэн маргаан болон холбогдон гарсан гэрээний үүргийг зөрчсөн, гэрээг дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой бүх маргааныг Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлэх зохицуулалттай.

7.Төр бүсээ чангалж, төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлыг танаж байгаа энэ үед ТЭЗҮ болон холбогдох нөхцөл нь өөрчлөгдсөн, эдийн засгийн үр ашиг нь тодорхойгүй, улсад аль хэдийн хохирол учруулаад байгаа мега нэртэй төсөлд хөрөнгө оруулах нь зөв шийдвэр эсэх тал дээр Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд Та ямар итгэл үнэмшил, байр суурьтай байгаа вэ? Засгийн газар "Туулын хурдны зам" төслийг одоогийн хэлбэрээр үргэлжлүүлэх, зогсоох, цуцлах, эсхүл шинэчлэн төлөвлөж хэрэгжүүлэхийн аль хувилбарыг сонгож байгаа вэ? Уг сонголтын хууль эрх зүй, эдийн засгийн үндэслэл, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, эдийн засгийн үр өгөөжийн тооцоог ирүүлнэ үү.

Хариулт. Энэхүү асуулгын хувьд Монгол Улсын Ерөнхий сайдын итгэл үнэмшил, байр суурийг тодруулсан байх тул хариулт өгөх боломжгүй байна.

Харин Улсын Их Хурлын гишүүний асуулгад дурдсан хохирлын тоо хэмжээ болон түүнд холбоотой гэм буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох асуудал одоогоор эрх бүхий байгууллагаас эцэслэн тогтоогдоогүй байгаа бөгөөд "Туулын хурдны зам"-ын ажил (Улаанбаатар) төслийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд нэр бүхий хүмүүст эрүүгийн хэрэг үүсгэж, зарим хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан ба төсөлтэй холбоотой мөрдөх байгууллагаас аливаа хориглолт, хязгаарлалт тогтоогоогүй байна. Энэ талаар Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс 2026 оны 06/8770 дугаар албан бичгийг ирүүлээд байна.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР